

2026 оны 07 сарын 29-ний өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Г

7

“ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ”

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 61 дүгээр зүйлийн 61.1.2, 61.4, 61.9, 65 дугаар зүйлийн 65.1, 71 дүгээр зүйлийн 71.3, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь хэсгүүд, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, компанийн дүрэм, компанийн нийт саналын эрх бүхий хувьцааны 63,39 хувийг эзэмшигч О.Батнарангийн 2026 оны 07 дугаар сарын 23-ний өдрийн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавилга” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал”-ыг Улаанбаатар хот, Хан-уул дүүргийн, 20-р хороо Чингисийн өргөн чөлөө-81 Ибис Стайлс Улаанбаатар зочид буудал /Мишээл экспогийн чанх хойно, Polaris их дэлгүүр/-ийн 4 давхарын хурлын танхимд 2026 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 10 цагт хуралдуулахаар тогтоосугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсүгэй. Үүнд:

2.1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох тухай;

2.2 Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай;

3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг 2026 оны 07 дугаар сарын 31-ний өдөрт багтаан Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зар”-ыг нэгдүгээр хавсралтаар баталж, 2026 оны 08 дугаар сарын 03-ний өдөр хувьцаа эзэмшигчдэд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргэх, мөн уг зарыг 2026 оны 08 дүгээр сарын 18-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин хурлын зар мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дэгийг хоёрдугаар хавсралт, хэлэлцэх асуудалтай холбогдох танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг гуравдугаар хавсралт, саналын хуудсыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

5. Ээлжит хурлыг зохион байгуулах комиссын гишүүд, хурал даргалагч, тооллогын комиссын дарга, гишүүдэд дараах албан тушаалтныг тус тус томилсугай. Үүнд

1. Хурал даргалагч: Ц.Банзрагч / ТУЗ-ийн дарга /

2. Хурал зохион байгуулах комиссын дарга: Ц.Баярмаа /Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн/

3. Хурал зохион байгуулах комиссын гишүүд: Х.Баяржаргал /Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга/
4. Тооллогын комиссын дарга: Б.Батцэнгэл
6. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 08 сарын 19-ний өдрөөр тогтоосугай.
7. Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл түүнтэй холбогдох баримт бичгийг 2026 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер, дилерийн компанид хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэх ажлыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
8. Тооллогын комисс Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийг удирдлага болгон ажилласугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ц.БАНЗРАГЧ